



## БОДЛОГЫН ТОЙМ: ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХУВЬЧЛАЛ ЯВУУЛАХ ДЭС ДАРААЛАЛ 2005 оны 8 дугаар сар

### Оршил

Эрчим хүч үйлдвэрлэгч төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газрыг худалдан авахыг сонирхож буй хувийн хөрөнгө оруулагчид өөрсдийн үйлдвэрлэсэн эрчим хүчний төлбөрийг авна гэдэгтээ зохих хэмжээгээр итгэлтэй байх ёстой. Улаанбаатар хотын 2 дугаар цахилгаан станцыг хувьчлах төндөрийг 2005 оны 5 дугаар сард зарлахад тодорхой санал ирүүлээгүй нь боломжит хөрөнгө оруулагчид нь тус салбарын одоогийн төлбөр тооцооны систем нь өдөр тутмын, байнгын үйл ажиллагааг явуулахад хүрэлцэхүйц орлогыг бий болгох, тус салбарт хуримтлагдсан асар их хэмжээний өрийг төлөх, үүний зэрэгцээгээр хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэнэ гэдэгт бүрэн дүүрэн итгэхгүй байгааг харуулсан.

Монгол Улсын Засгийн Газар (ЗГ) цаашид эрчим хүчний салбарт ийм хүндрэл үүсэхээс сэргийлж, дараах шаардлагыг хангахын тулд хувьчлалыг зохих дэс дараалалтай хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Эрчим хүч үйлдвэрлэгч төрийн өмчийн компаниудыг худалдан авах хөрөнгө оруулагчдад өөрсдийн үйлдвэрлэсэн дулаан, эрчим хүчний төлбөрийг бүрэн, хугацаанд нь авах итгэл үнэмшлийг бий болгох
- Тэдгээр хөрөнгө оруулагчдад төсвийн орлогоор баталгаа гаргаж өгөхөөс зайлсхийх
- Монгол Улсын эрчим хүчний салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах.

### Зөвлөмж

1. Эрчим хүч түгээх, хангах компаниудад бэлэн мөнгө хуримтлагддаг учраас юуны өмнө тэдгээрийг хувьчлах; өөрөөр хэлбэл "бэлэн мөнгөний бүртгэлийг юуны өмнө засч залруулж авах." Хувийн хэвшлийн менежмент нь орлогыг хугацаанд нь бүрдүүлэх ажлыг эрс сайжруулах
2. Хураасан үнэ тариф зардлаа нөхөж, хөрөнгө оруулагчдад боломжийн өгөөж өгөхүйц нөхцлийг бүрдүүлэх
3. Гэрээг дагаж мөрдөн, шийтгэл үзүүлэх арга хэмжээ нь үйлчилгээний төлбөрөө төлдөггүй "дураараа загнагсад"-ын үйлдлийг багасгах хэмжээнд үйлчилдэг эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлж төлөвшүүлэх

АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ Төслөөс дэмжиж, Эрчим Хүчний Зохицуулах Газар (ЭХЗГ)-т хэрэгжиж буй ажлын үр дүнд Монгол Улсад зардалд үндэслэсэн, шударга, ил тод үнэ тарифийн тогтолцоог бий болгох чиглэлд тогтвортой дэвшил гарч байна. Харин хөрөнгө оруулагчдад илүү таатай эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлэх талаар гарах дэвшил удаашралтай байна.

Хэрэв зардлыг тарифын орлогоос санхүүжүүлбэл эрчим хүчний системд эрчим хүчний үйлдвэрлэлийн төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн төлөх хангалттай мөнгө хуримтлагдана. Эрчим хүч түгээх/хангах компани зардлыг төлнө гэдэгт хөрөнгө оруулагчид итгэлтэй байх тохиолдолд тэд орлогын баталгааг ЗГ-аас эсвэл өөр эх үүсвэрээс шаардах хэрэггүй болох бөгөөд эсвэл зөвхөн хэсэгчилсэн баталгааг шаардах болно. Иймд хэрэглэгчдээс төлбөрийг шууд авдаг эрчим хүч нийлүүлдэг газруудыг юуны түрүүнд хувьчлахыг санал болгож байна. Ийм хандлагыг цэвэр, бохир ус гэх мэт дэд бүтцийн бусад үйлчилгээнд мөн баримталж болох юм.

### Боломжит өгөөж

- Дулаан болон цахилгаан түгээх/хангах компаний хувьчлал амжилттай явагдвал үйлдвэрлэгчийг хувьчлахад хялбар болно. Учир нь боломжит хөрөнгө оруулагчид төлбөр төлөгдөнө гэдэгт илүү итгэлтэй байх бөгөөд ингэснээр тэдний хөрөнгө оруулалтын эрсдэл багасна.
- Үйлдвэрлэлчийн хөрөнгө илүү сонирхол татаж, илүү үнэд хүрнэ.
- Монгол Улсын ЗГ үйлдвэрлэгчийн хөрөнгийг хөрөнгө оруулагчдад боломжийн болгохын тулд хувийн эрчим хүч үйлдвэрлэгчдэд ямар ч баталгаа гаргахгүй эсвэл зөвхөн төлбөрийн хэсэгчилсэн баталгаа гаргаж болох юм.
- Санхүүгийн салбарын хувьд ЗГ-ын баталгааг өр төлбөр буюу зээл гэж үздэг тул ЗГ өөрийн зээл авах чадвар болон зээлийн зэрэглэлийг хамгаална.

### Мэдээллийн эх сурвалж

- АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ Төсөл, "Бодлогын тойм: "Эрчим хүчний салбарыг хувьчлах төлөвлөгөө", 2004 оны 9 дүгээр сар
- АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ Төсөл, "ТӨХ-нд илгээсэн захидал, Хувьчлалын бодлогын талаарх санал", 2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр
- АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ Төсөл, "2, 3 дугаар цахилгаан станцын хувьцаа эзэмшигчдэд илгээсэн захидал", 2005 оны 7 дугаар сарын 28-ны өдөр